**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01. сарын 17-ны өдөр Дугаар БА-015/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 31 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий хүчин чадалтай үйлчилгээтэй зочид буудлын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03 -ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 0013525, зөвшөөрлийн дугаар: БАЗГ2023/615;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: САТ-23/06-02;

2.3. Захиалагч: Иргэн Боржигон овог, Лхагва эцэг эхийн нэр, Моломжамц өөрийн нэр, ХВ80062613 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, булгийн 1 гудамж 31 тоот, 99093038 холбоо барих утас, molomjamts1512@gmail.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Тэгш Аравт ХХК оноосон нэр, 9011556092 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5991617 регистрийн дугаар, БУ17-203/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 19 дүгээр хороо, 21 дүгээр хороолол, 58-31 тоот, 91110555 88118504 холбоо барих утас, uchral91@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Дүүрэн гол ХХК оноосон нэр, 9011759136 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6368204 регистрийн дугаар, БУ17-148/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, залуус хороолол, 48а-1019 тоот, 89070071 холбоо барих утас;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Каталист прожект ХХК оноосон нэр, 9011834751 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6801056 регистрийн дугаар, ЗТ12-827/22 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, 98/2, 33 тоот, 99594424 холбоо барих утас, nouhaus.llc@gmail.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: ОСНАУГ,ОНӨААТҮГ хэрэглэгчдэд үйлчлэх 13 дугаар төв, 2117118 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Их тойруу, өөрийн байр, 70005454 70111753 холбоо барих утас, info@osnaaug.ub.gov.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

ХЯНАЛТ Ш
ГА
Барилга байгуула
оруула

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий хүчин чадалтай үйлчилгээтэй зочид буудлын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 36 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий хүчин чадалтай үйлчилгээтэй зочид буудлын зориулалттай барилга байгууламжид ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Баянгол дүүргийн 31 дүгээр хороо,
Иргэн Л.Моломжамцын захиалгатай, зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээтэй зочид буудлын барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
Бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Иргэн (Л.Моломжамц)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 646
Огноо: 2025 он 01 сар 17 өдөр
Бүртгэсэн:
УЛААНБААТАР ХОТ ТТМ №1584

## БАЯНГОЛ ДҮҮРЭГ 31 ДУГААР ХОРОО, ИРГЭН Л.МОЛОМЖАМЦЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 7 ДАВХАР 1 БЛОК, 4 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ЗОЧИД БУУДЛЫН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 11 Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 31 дүгээр хороо, иргэн Л.Моломжамцын захиалгатай, зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий үйлчилгээтэй зочид буудлын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхарт 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 13:30 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:40 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1 | Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: захиалагч иргэн | Л.Моломжамц |
| 3 | Нийслэлийн Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 4 | Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5 | Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Г.Үүрийнгэгээ |
| 6 | Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Ц.Дагвадорж |
| 7 | Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 8 | Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын тасаг, дэд хурандаа | М.Батсайхан |
| 9 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК техникийн хяналтын инженер | Ц.Наранцацрал |
| 10 | Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК БТТ-ийн ахлах инженер | Э.Ундрахцогт |
| 11 | Үндэсний төв архив зураг төслийн баримтын архивын архивч | Н.Өлзийжаргал |

| | | |
|---|---|---|
| 12 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Д.Ганбат |
| 13 | Зураг төслийн Каталист прожект ХХК-ийн захирал | С.Мөнхбаяр |
| 14 | Ашиглалт хариуцах байгууллага ОСНААУГ ХҮТ 13-ийн ахлах инженер | Б.Баасансүрэн |
| 15 | Гүйцэтгэгч Тэгш аравт ХХК-ийн захирал | Ч.Учралбаяр |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 31 дүгээр хороо, иргэн Л.Моломжамцын захиалгатай, зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий үйлчилгээтэй зочид буудлын барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Барилга угсралтын ажил гүйцэтгэх тэмдэглэлд тэмдэг дарж баталгаажуулах, зураг төслийн байгууллагын өгсөн үүрэг шаардлага зөвлөмжийн биелэлт дүгнэлтийг зураг төслийн байгууллагын төлөөлөгч баталгаажуулаагүй байгааг гүйцэд хянуулах:
- Зохиогчийн дүгнэлтийг баяжуулан засварлаж хянуулахдаа гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулан өөрчлөлт хийсэн талаар, мөн барилгын бетон , арматурын шинжилгээний дүнг хөндлөнгийн лабраторын шинжилгээгээр оруулсан дүн мэдээг тодорхой тусгаж дахин хянуулах:

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзоглмаа:**

- Гадна дулааны худгийг цэвэрлэгээ хийж шугамыг дуулаалах:
- Өрөөнд халаах хэрэгсэлүүдэд термостат суурилуулах:
- Дулааны узелийг хаягжуулах:
- Гадна дулаан хангамжийн системийн угсралт, УДДТ- ын холигч насосны узелын зангилаа шахсан акт, тоног төхөөрөмж угсралтын ил далд ажилын акт бүрэн баталгаажуулах;
- АС -н системийн угсралтын далд актыг шалгуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны Шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- №432/23 тоот техникийн нөхцөлийн хугацаа дууссан тул хүсэлт өгч сунгах;
- ОСНААУГ-н №85/2024 дугаар тодруулагын дагуу техникийн нөхцөл шинээр гаргуулах;
- 2023.08.09 өдрийн батлагдсан ажилын зургийн дагуу бохир усны буух 1, буух 2 худаг угсраагүй шугамыг эзэмшигчтэй зөвшилцөөгүй;
- Гадна цэвэр усны дагуйн зүсэлт байхгүй, Ойролцоогоор 10-20м шугам шинэчлээгүй, хуучин нураасан барилгын шугамаас холболт хийсэн;
- Бохир усны трап зурагаас өөрчлөлттэй суурилуулагүй
- Узелд даралт хэмжих хэмжигч, тоолуурын өмнө хог шүүгч суурилуулах
- Гадна цэвэр, бохир усны шугамын гүйцэтгэлийн зураг хийлгэх, мэдээллийн санд оруулсан акт шалгуулах
- Гадна цэвэр усны акт үйлдэх /үйлдээгүй/
- Бохир усны шугамын ил далд ажилын акт буруу бичигдсэн засах ;
- Ундны уснаас сорьц авч дүгнэлт шалгуулах;
- Усны тоолуурын гэрчилгээ шалгуулах;
- Нөөцийн савны /v-4мкуб/ хэмжээг багасгасан тайлбар дүгнэлт,баталгаа ирүүлэх , хийх зайгүй, таазанд тулсан;
- Нөөцийн савны угсралт, халдваргүйжүүлэлтийн тусгай зөвшөөрөл;

Ашиглалтанд оруулах боложгүй.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Дотуур холбооны станц суурилуулж ажиллуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах:**

- Техникийн давхарын дээврийн усны хаялганы буултыг хийх;
- Консолийн дулаалга хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх;
- БТХ-ийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын тасаг, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Галын дохиолол мэдээлэгч ажиллаагүй;
- ГК гал унтраах дотор усан хангамж ажиллаагүй;

- Бүх давхарт ердийн болон цахилгаан шатыг тусгаарлах хаалга зураг төслийн дагуу хийх;
- Дотор засал гадна дулаалга материалын гал тэсвэрлэлтийн зэрэг тогтоосон дүгнэлт үзүүлэх;
- Техникийн давхарыг батлагдсан зураг төалийн дагуу болгох
- Цахилгааны өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж суурилуулах

Г ШАЛГА
ГАЗАР
уламжийг
улах коми

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК техникийн хяналтын инженер **Ц.Наранцацрал:**

- Техникийн нөхцөл 15/01330/23 120ква дагуу шүлжээнд холбогдсон холболтын протокол үзүүлэх;
- 0,4квт кабелийг нийслэлийн тэдээллийн санд бүртгүүлж акт авах;
- Лифт дулааны узелийн өрөөний тоноглолын суурийг давтан газардуулагын хүрээтэй холбож гагнах;
- Газардуулга, аянгын ил далд ажилын актыг эрчим хүчний барилга байгууламж барих ажилын хавсралт М39т маягтын дагуу хийцлэлийг дэлгэрэнгүй бичиж дүгнэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, БТТ-ийн ахлах инженер **Э.Ундрахцогт:**

- Гадна худаг цэвэрлэж худаг доторхи шугам будаж дулаалах;
- Холигч узелийн темпратур тохируулах автомат удирдлагын контроллёр ажилд оруулж тохируулах;
- Холигч узелийн дутуу дулаалга хийж гүйцээх;
- Халаагч хэрэгслүүдэд термостат винтел суурилуулах
- ХХУ-ны Техникийн нөхцөл авах, Техникийн нөхцөл автал ХХУ-г Техникийн нөхцөл болон ГД, ДМ-ийн батлагдсан зурагт заасны дагуу эрчим хүчний хэмнэлттэй өөр эх үүсвэрээр шийдэх;

Үүрэг даалгавараар ашиглатанд оруулах саналтай.

Үндэсний төв архив зураг төслийн баримтын архивийн архивч **Н.Өлзийжаргал:**

- Хувийн хэрэгт НЗД-ийн захирамж, лифтний дүгнэлт, Чанарын баталгаа хавсаргах;
- Ил далд ажилын акт, гэрэл зураг, материалын сертификатыг бүрэн бүрдүүлэх хуудас дугаарлаж, дотоод товъёог үйлдэх;
- Ажилын зураг болон холбогдох баримтын баримтын эх хувийг архивт хүлээлгэн өгөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Д.Ганбат:**

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам стандарт бус байна. Халтирхаас хамгаалсан наалт наах ;
- Орох хаалганаас цахилгаан шат хүртэл зайд тэргэнцэртэй хүн явхад саадгүй болгох;
- Цахилгаан шатыг Монгол хэлээр ярьдаг болгох болон давхар бүрт брайль тэмдэглэгээ хийх тоо мөн чиглүүлэгч хийх
- Өрөөний хаалганы хаянжилт болон тоог хүртээмжтэй брайль болон томруулсан байдлаар хийх
- Үүрэг даалгаварын биелэлтийг фото зургаар баталгаажуулан өгөх ;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглатад авах саналтай байна.

Зураг төслийн Каталист прожект ХХК-ийн захирал **С.Мөнхбаяр:**

- 2-7 давхарт утаа тусгаарлах хаалгыг зураг төслийн дагуу хийх;
- Техникийн давхарын ажилчдын байрлах өрөөнд гүйцэтгэлийн зураг хийлгэж баталгаажуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ашиглалт хариуцах байгууллага ОСНААУГ ХҮТ 13-ийн ахлах инженер **Б.Баасансүрэн:**

- Дулааны худаг цэвэрлэх
- Бохирын худаг лайдаж цэвэрлэх
- ОСНААУГ-ийн тодруулагын дагуу хийгдэх ТД-100-52/62 насос, давтамж хувиргагч суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Захиалагч **Л.Моломжамц:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Гүйцэтгэгч Тэгш аравт ХХК-ийн захирал **Ч.Учралбаяр:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- Бнбд 11-04-16 дагуу барилгад дүгнэлт гаргах;
- БТХ-ийн дагуу барилгад чанар баталгаа гарган албан тоотоор ирүүлэх;
- Давхаруудын галын хаалгыг хийж гүйцэтгэх /зургийн дагуу/;
- В1 давхар уруу орох гарах хэсэгт саравч, дээвэр хийж гарах хөдөлгөөний урсгалд норм стандартын дагуу гүйцэтгэх;
- Галын аваарын гарцны хоёр талд бариул хийх;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянгол дүүргийн 31 дүгээр хороо, иргэн Л.Моломжамцын захиалгатай, зоорьтой 7 давхар 1 блок, 4 (дөрөв) автомашины дулаан зогсоол бүхий үйлчилгээтэй зочид буудлын барилгыг ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ (А.Мөнгөн)

9024041846
8314551 СБТ24866

Тэмдэглэл хөтөлсөн:
Иргэн ........................ (Л.Моломжамц)